# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар

## 2022 оны хагас жил

| Шийдвэр | Заалт | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай 2009-07-16 Дугаар 2009.07.16 | 5.3.. Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно. (5.2.Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.) | Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүй, хууль бусаар зөөж тээвэрлэх үйл ажиллагаанд иргэдтэй хамтран хяналт тавин ажиллаж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүй тээвэрлэсэн 3 зөрчил илрүүлж, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлсэн. Зөрчлийн тухай хуулийн дагуу 260000 төгрөгний нөхөн төлбөрийг төлүүлсэн. | 70% | 70% |
| 2 | 2 | Жендэрийн эрх тэгш байдлыг | 19.1.8. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны | Ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын судалгааг аймгийн нийгмийн бодлогын | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хангах тухай 2011-02-02 Дугаар 2011.02.02 | байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх; | хэлтэст хугацаанд хүргүүлсэн. Энэхүү судалгаагаар Тамгын газрын нийт албан хаагчдын 48.2% нь эрэгтэй, 51.8% нь эмэгтэй албан хаагч эзлэж байна. Мөн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтад 33 албан хаагч буюу 75%, ахисан түвшний жендэр, жендэрийн мэдрэмжтэй харилцаа сургалтад давхардсан тоогоор 40 албан хаагч хамрагдсаж гэрчилгээтэй болсон. | | |
| 3 | 3 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Тамгын газрын чиг үүрэгт хамаарахгүй. | Х.Б | 0% |
| | 4 | | 18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх | Тамгын газрын бүрэн эрхэд хамраахгүй. | Х.Б | Х.Б |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | |
| | 5 | | 18.1.3.. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Тамгын газарт хамаарахгүй | Х.Б | Х.Б |
| | 6 | | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг | Нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд Хайр дүүрэн гэр бүл аян зохион | 100% | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | байгуулсан. Аяны хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн Үүнд: -ЕБС-ийн 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ гар зургийн уралдаан, -ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, МСҮТ-ийн суралцагч нарын дунд "хайр дүүрэн амьдрах хамгийн сайхан" сэдэвт эсээ бичлэгийн уралдаан, -Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг богино хэмжээний өгүүлэмж, шторк, -Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны гишүүн 4 гэр бүлийн 8 иргэнийг оролцуулан “Буянтай сайхан хань” арга хэмжээ, -Аймгийн ахмадын холбооны тэргүүн, тэргүүлэгч гишүүд болон нийт 60 ахмад оролцуулсан “Хайр дүүрэн гэр бүл” ахмадын өдөрлөг, -Баруун -Урт сумын 9-н багийн 80 гаруй зорилтот бүлгийн иргэдэд зориулж аймгийн цагдаагийн газар, ГБХЗХГазар, Нэгдсэн эмнэлэг, Монгол банк зэрэг байгууллагуудын зочин илтгэгч нарыг урьж оролцуулан Гэр бүлийн харилцаа, хувь хүний үнэт зүйл, мэргэжлийн боловсрол, өрхийн санхүүгийн боловсрол сэдвүүдээр сонирхолтой илтгэл, эрх зүйн мэдээ, мэдээллүүдийг тус тус өгч ажилласан. Мөн "Зөв хэвшил-зөв амьдрал" хөтөлбөр батлуулан, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: “Өглөөний гүйлтэд нэгдэцгээе" сарын аяныг зохион байгуулсан.Аянд албан ёсоор тус сумын харъяа 21 байгууллага нэгдэж, хамтран ажиллаж байна. Сүхбаатар аймаг дахь Лидер Сурагч Академитай хамтран хүүхдээр дамжуулж нийгэмд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх зорилгоор "ОЮУНЫ ДАВАЛГАА-IV" аймгийн “Уран илтгэл”-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгууллаа.Тэмцээнд 4 сумын 16 сурагч оролцлоо. ”Архигүй нийгэм бидний нүд”-ээр эссэ бичлэгийн уралдааны эхний 2 байранд шалгарсан илтгэлд хоолой бичүүлэн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд таниулсан. | | |
| | 7 | | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг | Баруун-Урт сумын ИТХ-ын 2021 оны 4/03 тоот тогтоолоор сумын хамтарсан багийн гишүүдийг шинэчлэн байгуулан баталж, Засаг даргын 2021 оны 08 тоот захирамжаар баг бүрт хамтарсан баг байгуулан ажиллаж байна. Сумын хэмжээнд хагас жилийн байдлаар 10-н хамтарсан багт 64 гишүүний чадавхжуулан | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлнэ:) | сургалтыг танхимаар нэг удаа, хамтарсан багийн дарга нарийн бичгийг мэргэшүүлэх сургалтыг танхимаар 2 удаа сургалтад хамруулллаа. | | |
| | 8 | | 19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Зөв хэвшил-зөв амьдрал хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан сумын ИТХ-аар батлуулан ажиллаж байна. Мөн хөтөлбөр хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 20.000.000 төгрөг төсөвлөсөн. | 100% | 70% |
| | 9 | | 19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулахад зориулж сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд 155000000 төгрөгийг мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн. | | |
| | 10 | | 19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”-тай хамтран "It's Ok Not To Be Ok" төслийг хэрэгжүүлсэн.Төслийн хүрээнд мэргэжлийн сэтгэл зүйчтэй хамтран гэр бүл, охид, эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Тамгын газарт хохирогчид зөвлөгөө өгөх, ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулан 16 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг сумын ИТХ-ын тогтоолоор томилон, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. АА нийгэмлэг, АНЭ-ийн Сэтгэц наркологийн тасагтай хамтран ажиллаж архины хамааралтай иргэдийг уг бүлгийн цуглаанд хамруулан хорт зуршлаас нь салгахад анхааран ажиллаж байна. Тус суманд 2 бүлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 60 гаруй иргэд хамрагдаж байна.Тайлант хугацаанд аймгийн Сэтгэц наркологийн | 70% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тасагт 97 иргэн хэвтэн эмчлүүлж, хор тайлах болон сэтгэл заслын эмчилгээ хийлгэж, зөвлөгөө авсан. Тус суманд 10 олон нийтийн байцаагч ажиллаж хохирогчдод үйлчилгээ үзүүлж байна. | | |
| | 11 | | 19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр АА нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна. Тус суманд 2 АА бүлэг, давхар хамаарлын 1 бүлэг үйл ажиллагаа явуулж байна.Уг бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, цуглаан хийх байрыг засварлаж өгсөн. Мөн тус бүлгийг бүсийн уулзалтад оролцоход нь зориулж 500000 төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлсэн. | 70% | 70% |
| | 12 | | 19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг | “Гэр бүлүүдийн тулгамдаж буй асуудал, хүүхэд хүмүүжил, гэр бүлийн эерэг харилцаа хандлагыг бий болгох, гэр бүлийн үнэ цэнийг хадгалж хамгаалах, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор “МИНИЙ ГЭР БҮЛ” ток шоуг зохион байгууллаа. Арга хэмжэээд багийн ажлын алба, 9-р багийн аймаг, сумын хурлын төлөөлөгч нар, 17 гэр бүл оролцож нийт 40 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд зочин гэр | 70% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлнэ:) | бүлээр Д.Бат-очир, И.Гэрэлт-Од нарын гэр бүл оролцож гэр бүлийн эерэг харилцаа, хүүхэд хүмүүжүүлэх арга зүй, ухаалаг утас төхөөрөмжөөс хүүхдүүдээ хэрхэн хол байлгах гэх мэт олон асуудлыг ярилцсан үр дүнтэй уулзалт ярилцлага болсон. -Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, Баруун-Урт сумын ард иргэдийг аюулгүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг нэмэгдүүлж, архидан согтуурахтай тэмцэх, эрүүл аж төрөх зан заншил төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зөв хэвшил-Зөв амьдрал хөтөлбөрийг боловсруулан сумын ИТХ-аар, жилийн ажлын төлөвлөгөөг гарган Засаг даргаар тус тус батлуулан ажиллаж байна. Мөн байгууллагын цахим хуудсаар болон Баруун-Урт Сум Зөв Хэвшил-Зөв Амьдрал хуудсаар дамжуулан иргэдэд 2 подкаст, 30 постер 2 voice хүргэж ажиллалаа. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | 13 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Жил бүр тус Тамгын газрын Хүний нөөцийн ажилтан албан хаагчдын мэргэжил, ур чадварын нэмэгдүүлэх сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын дагуу боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайн оны эхний хагас жилд харъяа төсөвт байгууллагуудаас /ЕБС-4, СӨБ-11, ОНӨААТҮГ-3/ төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн зорилтот түвшинг нэгтгэж, жилийн эцэст нэгтгэл тайланг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70% | 70% |
| 5 | 14 | Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01 | 8.1.. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно. | Сумын ИТХ-аар татварын хувь хэмжээг шинээр тогтоосон буюу өөрчилсөн татвар байхгүй. | 70% | 70% |
| 6 | 15 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, | Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | ажлыг 2022 оны зорилт болгож чанарын багийг 18 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээс өмнө алсын хараа, үнэт зүйл гэсэн ойлголт баримт, бичиг байхгүй байсан. Тиймээс иргэдэд хүргэх үйлчилгээгээ чанаржуулахын тулд бид алс хэт, эрхэм зорилго, үнэт зүйлээ засгийн засгаас хэрэгжүүлж буй стратеги төлөвлөгөөтэй /алсын хараа 2050/ уялдуулан боловсруулах, хэрэгцээ шаардлага гарсан. Тиймээс төслийн баг байгууллагын алсын хараа, эрхэм, зорилго, үнэт зүйлийг тодорхойлж нийт албан хаагчдаар хэлэлцүүлэн батлаж, мэдээллийн самбартаа байршуулаад байна. Манай алсын хараа: Иргэн төвтэй хөгжлийн бодлогод тулгуурласан, амьдрахад таатай хөгжлийн загвар хот болон хөгжинө. Манай эрхэм зорилго: Орон нутгийн онцлогт нийцсэн олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлж, цахимд суурилсан төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. Манай үнэт зүйл: - Иргэн төвтэй бодлого - Чадварла, ёс зүйтэй, хариуцлагатай албан хаагч - Чанар, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүртээмжтэй үйлчилгээ | | |
| | 16 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн захиргааны байгууллага бөгөөд иргэдэд төрийн анхан шатны үйлчилгээг үзүүлэх, сумын хэмжээнд бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Засаг даргын тамгын газар нь - Удирдлага - Захирагчийн алба - Санхүү алба - Хөдөө аж ахуйн тасаг - Иргэдэд үйлчлэх төв - мал эмнэлгийн тасаг - Зохион байгуулалт үйлчилгээний тасаг гэсэн 7 нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 7 дугаар баг Балдан осорын гудамж 415 тоот, Иргэдийн санал хүсэлтийг 7051-1111 утсаар ажлын өдрүүдэд ажлын цагаар авч ажиллаж байна. Мөн хууль эрх зүйн мэргэжилтэн бичгээр өргөдөл, гомдол санал хүсэлт хүлээн авч байгаа тухай мэдээллийг самбартаа байршуулсан. Олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх, нийгмийн сүлжээний дараах хаягуудыг ашиглаж байна. 1.Албан ёсны сайт: https://baruun-urt.su.gov.mn/ 2. Албан ёсны фэйсбүүк пейжийн хаяг: | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | https://www.facebook.com/BUZDTG | | |
| | 17 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч, хариу барагдуулж ажилладаг. | 100% | 70% |
| | 18 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Сумын Засаг даргад бүрэн эрх олгосон хуулийг хяналтад авч, тайланг хагас жилээр гарган аймгийн ХЭЗХ-т хүргүүлсэн. Мөн Хуулийн хэрэгжилтийг аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санд 6 хуулийн 29 заалтын хэрэгжилтийг тайлагнасан. | 100% | 100% |
| | 19 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг 6 бүлэг 141 заалтаар боловсруулан сумын ИТХ-аар батлуулан ажилласан. Хэрэгжилтийн тайланг хагас жилээр гарган аймгийн ХШҮДАХ-т хүргүүлэхээр ажиллаж байна. | 100% | 100% |
| | 20 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, | Хагас жилийн тайланг цахим системд тайлагнаж байгаатай холбогдуулан ажлын | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | хэсгийн гишүүн бүрт зөвлөгөө, зөвлөмж, чиглэл өгч ажиллаж байна. Хагас жилийн байдлаар: МУ-ын 5 хууль 13 заалт УИХ-ын 1 тогтоол 1 заалт УИХ-ын байнгын хорооны 1 тогтоол 1 заалт Ерөнхийлөгчийн 4 зарлиг 6 заалт ҮАБЗ-ийн 1 зөвлөмж 1 заалт ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл ЗГ-ын 11 тогтоол 30 ЗГ-ын хуралдааны 2 тэмдэглллийн 2 заалт ЗГ-ын албан 3 даалгавар 16 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа.Үүнд: Бүрэн хэрэгжсэн -51, хэрэгжих шатанд-14, хэрэгжилт хангалтгүй -1, Хугацаа болоогүй-6 арга хэмжээ байна. Хагас жилийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 92.5% байна. | | |
| | 21 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Албан тушаалын тодорхойлолт зааснаар Хууль эрх зүйн мэргэжилтэн нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах,сурталчлах, мэдээллээр хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, гүйцэтгэлийн үр дүн өмнө Тамгын газрын даргын өмнө хариуцна. Хууль эрхзүйн мэргэжилтэн Амарсайханы Өлзийжаргал, | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 9915-3743 ulziijargal@sukhbaatar.gov.mn | | |
| | 22 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Тус Тамгын газарт хагас жилийн байдлаар 550 өргөдөл ирсэн байна. Үүнээс чиг үүргийн дагуу 80 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн. 469 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч, эргэх холбоотой ажилласан.Хугацаа болоогүй 1 өргөдөл байна. Өргөдөл гомдлын барагдуулалт 100% байна.Өргөдөл, гомдлын барагдуулалтад Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн А.Өлзийжаргал хяналт тавин ажиллаж байна.Өргөдөл гомдлын улирлын тайланг улирал бүрийн 25-нд хугацаанд нь тайлагнадаг. | 100% | 100% |
| | 23 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | үйл ажиллагааны чиглэлд хамаарах статистик мэдээлэл, мэдээллийг хугацаанд нь гаргаж хэвшсэн. | 100% | 70% |
| | 24 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Тус Тамгын газрын хэвлэл мэдээлэл ажилтан нь байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилладаг.Иргэдэд мэдээллээр хангах, байгууллагын мэдээллийн ил тод байдлыг | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | сайжруулахын тулд мэдээлэл, солилцох, дамжуулах зааврын төслийн чанарын удирдлагын тогтолцооны чанарын баг боловсруулж хэлэлцүүлсэн. Энэхүү зааврааp албан хаагчид долоо хоног бүрийн Даваа гарагийн 9.00 цагт хэлэл, мэдээллийн ажилтанд өнгөрсөн долоо хоногт хийсэн ажлаа тайлагнах, нэгтгэл тайлан хэвлэл, мэдээллийн аижлтан 11 цагт удирдлагад танилцуулга слайд бэлтгэн хүлээлгэсэн. | | |
| | 25 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажиллаж байна.Тус байгууллагад ёс зүйн зөвлөл ажиллаж бөгөөд даргыг нь чадавхжуулах сургалтад хамруулсан.Ёс зүйн зөвлөлөөс дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.Үүнд -ЗӨВ ХАНДЛАГА-ЭЕРЭГ НӨЛӨӨ АЯНД НЭГДЭЖ төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг сурталчилсан. -төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг хэвлэн албан хаагч бүрийн нүдэнд харагдахуйц байдлаар байршуулсан. Манай байгууллага төрийн байгууллага дүрмийг баримтлан ажиллаж байна. 1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлчилгээний албан хаагчийн ёсзүйн дүрэм” 2. Сумын тамгын газрын хамт олны 2022 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар нэмэлт өөрчлөлтөөр төрийн албаны тухайлийн 40 дүгээр зүйлийг мөрдөн ажиллах, зөрчсөн тоиолдолд авах хариуцлагын талаар тусгасан. 3. Байгууллагынёс зүйн хорооноос төслийг санаачилж, нийт албан хаагчдаар хэлэлцүүлэгдэн батлагдсан “Ёсзүйн дүрэм” –ийг 2021 онд боловсруулж батлуулсан. 4. Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэхтэй холбоотой чанарын багийн боловсруулсан үйлчилгээ үзүүлэх журам-д ёсзүйн талаар дэлгэрэнгүй тусгасан. Мөн төрийн албан хаагчийн эрхэмлэх 9-н зүйлийг албан хаагчид өдөр тутмын ажилдаа мөрдөн ажиллах, харж санаж байхад туслах зорилгоорА5 хэмжээтэйгээр хэвлэж 41 албан хаагчдад тараасан. Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9-н зүйлийг ведио хэлбэрт оруулан олон нийтийн сүлжээнд байршуулж төрийн албан хаагчдад өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байхыг уриалсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 26 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Хугацаа болоогүй | Х.Б | 0% |
| | 27 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Үзүүлж буй үйлчилгээ, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг гарган байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | 100% | 100% |
| | 28 | | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | -Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл -Тамхи худалдан борлуулах зөвшөөрөл -Согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг гарган мэдээллийн самбарт байршуулсан. Сумын Засаг даргын А/88 тоот захирамжаар ажлын хэсгийн томилон үйл ажиллагаанд хяналт хийсэн. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн тус сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Хөх хулганы орон, Багачуудын орон хүүхэд харах үйлчилгээнд сумын Засаг даргын А/98 тоот захирамжаар зөвшөөрөл олгосон. | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 29 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Иргэдэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэх зорилгоор орон нутгийн bbs телевиз, Сүхбаатарын өнгө сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулсан. Манай захиалгын үндсэн дээр 2 нэвтрүүлэг, 8 богино хэмжээний видио, текстэн мэдээллийг тухай бүр иргэдэд хүргэж ажилласан. | 100% | 100% |
| | 30 | | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Хуулиар нууцын зэрэгт оруулаагүй мэдээллийг иргэдэд нээлттэй мэдээлж ажилласан. Мэдээллийг байгууллагын самбар болон байгууллагын албан ёсны сайт: https://baruun-urt.su.gov.mn/, албан ёсны фэйсбүүк пейжийн хаяг: https://www.facebook.com/BUZDTG иргэдэд нээлттэй хүргэдэг. | 100% | 100% |
| 7 | 31 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга | 1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг | Цар тахлын үед зорилтот бүлгийн 98, эрсдэлт бүлгийн 200 хүүхдийн нэрчилсэн судалгааг тус тус гарган ажилласан. Сумын хэмжээнд 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар Коронавируст халдварт өвчин 1486 хүүхдэд хүрсэн байна. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 06 дугаар сарын 06-ын өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдөр | 100% | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67 | дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:) | хүртлэх хугацаанд хүүхдийн Нархан сувилалыг ажиллуулж байна. Нархан сувилалд эмч, сувилагч, туслах багш, тогооч нийт 9 албан хаагч ажиллаж байна. Сувилалд 2-5 насны өвчлөмтгий, эрсдэлт бүлгийн 60 хүүхэд 2 ээлжээр хамрагдаж сэргээн засах эмчилгээ хийлгэн, сувилуулж байна. Уг ажилд Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сангаас 20,000,000 төгрөг төсөвлөсөн. | | |
| 8 | 32 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад зориулж 20,000,000 төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх санийн төсөвт тусгасан. | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | | | | |
| 9 | 33 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр "Хамтарсан багт" сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлаас 5 сая төгрөгийг төсөвлөсөн. Сумын хамтарсан баг нь жил бүр төлөвлөгөөгөө сумын ИТХ-аар батлуулан гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хагас жилээр тайланг хүргүүлэн, хамтран ажиллаж байна. | 70% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | | | |
| 10 | 34 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Сумын харьяаны төсөвт 21-н байгууллагын 70 хувь нь байгууллагын гадна болон дотор хаягийг монгол хэл бичгээр хослуулан бичиж байршуулсан. | 70% | 70% |
| | 35 | | 4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, | Сумын Монгол хэл бичгийн орон тооны бус зөвлөлөөс Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | өөрийн харьяны төрийн захиргааны бүх шатны байгууллагын төрийн албан хэрэгт кирил болон үндэсний бичгийн хэм хэмжээг мөрдүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах, Харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд албан байгууллага, гудамж, талбайн нэр хаягийг кирил болон үндэсний бичгээр хослуулан бичиж хэвших, Төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтыг эрх бүхий байгууллагаас баталсан агуулгын дагуу авах зэрэг ажлуудыг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд аймгийн Боловсролын газартай хамтран "Хүмүүн бичиг- Хүн бүрийн бичиг", "Жаахан шаргын нутаг " зэрэг арга хэмжээг жил бүр уламжлал болгон зохион байгуулан ажиллаж байна. | | |
| 11 | 36 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104 | 2.. Амьд явах, амдрахын сайн сайхныг олон нийтэд сурталчилан таниулах, дээрх агуулага бүхий бүтээл, нэвтрүүлэг, мэдээлэлд ард иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг идэвхийлэн оролцохыг уриалсугай. | Иргэдийг соён гэгээрүүлэх, амьдрахын сайн сайхныг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор тус суманд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тайлан онд 5 нэвтрүүлэг 60 шторк хийсэн. | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | 37 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23 | 1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутагт нэн шаардлагатай ойн аж ахуйн инженерээр суралцах хүсэлтэй иргэн М.Өлзийжаргалын хүсэлтийг хүлээн авч аймгийн хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. М.Өлзийжаргал нь Хөдөө аж ахуйн их сургуульд 2,5 жилээр танхимаар суралцана. Энэ жилийн сургалтын төлбөрийн 2,508,000 төгрөгийн 30% болох 836,000 төгрөгийг дэмжлэг үзүүлэн холбогдох сургуулийн дансанд төвлөрүүлсэн Үлдэгдэл зардлыг тухайн суралцагч өөрөө болон ажиллаж байгаа байгууллага нь шийдвэрлэхээр болсон. | 100% | 70% |
| 13 | 38 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Бүх нийтээр мод тарих ажилд иргэдийн оролцоог хангах, мод тарих соёлыг иргэдэд сурталчлан таниулж, бүх нийтийн үйлс болгох зорилгоор 9 багийн 100 иргэнд 1137 ширхэг хайлаас, 130 ширхэг улиас, 486 ширхэг шар хуайс, нийт 1753 одыг иргэдийн сонголтоор 50%-ийн хөнгөлөлттэй олгосон. | 100% | 30% |
| | 39 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлигийн дагуу Тэрбум мод үндэсний мод үндэсний хөдөлгөөн өрнөж байгаатай | 100% | 30% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | холбогдуулан, 2030 он хүртэл Сүхбаатар аймаг нийт 10 сая модыг тарьж ургуулна. 2022 онд Баруун-Урт сумын хэмжээнд нийт 88909 ширхэг модыг 40 га газарт тарихаар төлөвлөсөн бөгөөд одоогийн байдлаар нийт 42446 ширхэг модыг хаврын тарилтаар тариад байна. Төрийн 70 байгууллага 27770 ширхэг мод, 3 ОНӨААТҮГ- 9345 ширхэг мод, 9 багийн 126 өрх 3734 ширхэг, хувийн хэвшил 1597 ширхэг модны суулгацыг тарьж ургуулаад байна. | | |
| 14 | 40 | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40 | 2.11. Хо, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах | Байгалийн гэнэтийн аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбай, үерийн далан ус зайлуулах системийг сар бүр нэг удаагийн давтамжтай цэвэрлүүлдэг. Нийт 277 тонн хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөж тээвэрлэсэн. | 100% | 30% |
| 15 | 41 | Газар | 6. . Газар хөдлөлтийн | Жил бүрийн 3 дугаар сарын 4-р долоо | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03 | гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | хоногт Гамшгийн бэлэн байдлыг үзэх шалгах үзлэг болох ба 03-р сарын 18-24-ны өдрүүдэд " Газар хөдлөлтийн аюулыг таниулах аян" зохион байгуулагдсан. НҮБ-н Гамшгийн эрсдлийг бууруулах газраас хотуудын гамшигтай тэмцэх чадавхийг бий болгох, бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй " Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь" санаачлагын хүрээнд аймгийн төвийн сумын гамшгийг тэсвэрлэх чадавхийг онооны аргаар үнэлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/117-р захирамжаар байгуулж 2022 оны 03-р сарын 09,10 өдрүүдэд аймгийн Онцгой байдлын газарт ажилласан. Ажлын хэсэг 17 хүний бүрэлдэхүүнтэй ба мэргэжлийн байгууллагуудын албан хаагчид хамрагдсан. Аюулгүй, гамшигт тэсвэртэй хотыг үнэлэх аргачлалын дагуу 10 бүлэгт хувааж үнэлэн нийт 141 оноо авахаас 92 оноо авч 65,2 хувьтай байна. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж нийт 66 хүний бүрэлдэхүүн шинэчлэсэн. | | |
| | 42 | | 11.. Барилга, хот байгуулалтын хууль, төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартын | Шинээр баригдаж буй барилга байгууламжийг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулж байна. Баруун-Урт | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | нөхцөл шаардлагыг зөрчсөн дутагдлыг арилгах, ялангуяа Улаанбаатар хотод ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй барилга барих, байшин хоорондын зайд норм зөрчин газар олгох явдлыг таслан зогсоох, (Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга) | сумын 1-р баг Мандал хорооллын 17-н айлын газар чөлөөлөлтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус барилгад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн барилгын насжилт дууссан хүн амьдрах нөхцөл боломжгүй гэсэн дүгнэлт гарсан. | | |
| 16 | 43 | ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257 | 2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ. | "Угийн бичиг- Удмийн бичиг" сургалтыг 1,2,3,6,8,9 дүгээр багийн 108 өрхөд зохион байгуулсан. Хагас жилийн байдлаар сумын угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 34 хувиар нэмэгдсэн. | 30% | 30% |
| 17 | 44 | Журам шинэчлэн батлах тухай 2016-01-11 | 2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн | Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасныг үндэслэн журам жинэчлэн батлах тухай тогтоолын дагуу Шилэн дансны цахим хуудсанд тавигдах | 100% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2016_29 | өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай. | мэдээллийг заасан цаг тухай бүр хяналтандаа авч ажиллаж байна. | | |
| 18 | 45 | Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018-05-23 Дугаар 2018_138 | 2.. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр | Баруун-Урт сумын хэмжээнд Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын 4 сургууль, 11-н цэцэрлэг, ОНӨААТҮГазар- 1 нийт 17-н төрийн байгууллага төрийн албаны цахим шуудан буюу ERP системд нэвтрүүлж байна. | 70% | 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй. | | | |
